



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 43

Номгон

**Дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК-ний үйл ажиллагааны бус орлогоос Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн үйл ажиллагааг дэмжиж, аймгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн орчин нөхцлийг сайжруулах зорилгоор тус корпорацид 5,0 сая төгрөгийн эх үүсвэрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг “Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөл /С.Готов/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг корпорацийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн орчин нөхцлийг сайжруулахад зарцуулахыг Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн гүйцэтгэх захирал /М.Мөнхбат/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



116755